

**Дундат иргэн улсаас Монголын тухайд
баримталсан бодлогыг нэхэн судлахуй
/1919 оноос хойш/**

Доктор /Ph/, профессор З.Понжид /МУИС/

XX зууны Монголын түүхийг судлан боловсруулахад зайлшгүй нягтлан үзэх олон асуудал байдгийн нэг бол 1919 онд ДИУ Монголын автономит эрхийг цуцласнаасаа хойш нэг жил хоёр сар гаруй хугацаанд Монголын тухайд явуулсан бодлого, үйл ажиллагаа юм. Манай улсын архивын сан хөмрөгт энэ сэдэвт холбогдох нилээд сурвалж баримт хадгалагдаж буй боловч одоо хүртэл шинжилгээ судлагааны эргэлтэнд бараг ороогүй байгаа аж. Иймд би уул баримтуудын зарим нэгийг ашиглаж энэхүү өгүүллийг бичлээ.

1919 оны намар Дундад иргэн улсын засгийн газар генерал Сюй Шу Жаныг баруун хойд хязгаарын хэргийг бодуулан шийтгэгч сайд бөгөөд гадаад монголын хойчийг сайжруулах элдэв зүйлийг ерөнхийлөн шийтгэгчийн тушаалд томилж дагалдах албаны түшмэл ба олон цэргийн хамт Монголд илгээсэн юм.

Сюй Шу Жан Монголд ирмэгцээ тус улсын автономит эрхийг хүч түрэмгийлэн цуцалж, Дундад иргэн улсын муж болгосон билээ. Энэ явдалд Богд хаантнаас эхлээд жирийн иргэд хүртэл ихээхэн дургүйцэж, улс орныхоо тусгаар тогтнолыг сэргээхийн тулд янз бүрийн арга сэдэж байлаа. Тиймээс ДИУ Монголын нөлөө бүхий хүмүүсийг тухайлбал төрд өндөр алба хашиж байсан ноёд язгууртан нэлээд хүнийг цол, хэргэм, одон тэмдгээр шагнаан урамшуулж, тэднийг өөртөө татах улмаар нийт монголчуудын эсэргүүцэл тэмцлийг хязгаарлах боломж бүрдүүлэхийг туйлаас хичээсэн билээ. Тухайлбал ДИУ-ийн ерөнхийлөгчийн зарлигаар Богдод "Гадаад Монголын сайныг зөвшин, соёлыг туслагч Богд Жибзундамба Хутагт хаан" цол, алтан тамга, алтан өргөмжлөл, давхар пүнлүү, суудлын сайн автомашин нэгийг, Богдын хатан Дондогдуламд "Тодорхой чадалтай, цэвэр мандал, эрдэнэ сэцэн гэгээн" гэдэг цол шагнажээ.

Ерөнхий сайд асан Бадамдоржид Чин вангийн хэргэм, давхар пүнлүү, суудлын машин 1, жил тутам 4000 лан мөнгө, Шүүх таслах яамны дэд сайд асан дайчин жонон ван Цогбадрах, Гадаад яамны дэд сайд асан далай чойнхор ван Цэдэнсоном, Шүүх таслах яамны дэд сайд асан чин зоригт чин ван лам Дашдэндэв нарт тус бүр Чин вангийн давхар пүнлүү, жил тутам 4000 лан мөнгө шагнаж байхаар болов.

Мөн Халх, Дөрвөдийн 6 аймгаас сэцэн хан Навааннэрэн, жонон ван Цогбадрах, ван Пунцагравдан, ван Ширнэндамдин, дархан чин ван Пунцагцэрэн, Далай Чойнхор ван Цэдэнсоном, ван Жамъяндорж, итгэмжит бэйс Цогт-Очир, ачит ван Гончигдамба, бэйл Сангабазар, гүн Аюурзана, жалханз хутагт Дамдинбазар, дилав хутагт Жамсранжав, чин ван лам Дашдэндэв, да лам Пунцагдорж, хамба лам Дагдан, зэрэг лам хар 16 хүнийг Бээжинд зочлуулж, элдэв хэрэг хэлэлцэхээр шийдвэрлэсэн нь чухамдаа тэднийг шагнаж урамшуулсан явдал байлаа. Эдгээр 16 хүний 7 нь Монгол Улсын автономит засгийн эрхийг цуцлахад гарын үсэг зурсан нөлөө бүхий хүмүүс байв. Ийнхүү монголын нөлөө бүхий хүмүүсийг ДИУ элдвээр шагнаан урамшуулж, итгэл хүлээлгэхийн сацуу, монголын аж ахуй эдийн засгийн талаар ямар бодлого чиглэл баримтлахаа урьдчилан боловсруулсан юм. Юуны өмнө монголын хуучин 5 яамны оронд улс төр, цэрэг, эдийн засгийн асуудал хариуцсан 8 газар байгуулахаар төлөвлөжээ. Тухайлбал:

1. Ерөнхий хэрэг эрхлэх газар

2. Эдийн засгийн хэрэг эрхлэх газар
3. Худалдааны хэрэг эрхлэх газар
4. Өртөөний хэрэг эрхлэх газар
5. Мал аж ахуй, газар тариалангийн хэрэг эрхлэх газар
6. Ой мод, уурхайн хэрэг эрхлэх газар
7. Ёслол сургуулийн хэрэг эрхлэх газар
8. Цэргийн хэрэг эрхлэх газар эдгээр болно.

Гэвч зардал төсөв, боловсон хүчний хүрэлцээгүйгээс болж, Дотоод, Гадаад Шүүх яамдад хамаарах асуудал хариуцсан цэргийн хэрэг эрхлэх газар, санхүү аж ахуйн асуудал эрхэлсэн эдийн засгийн хэрэг эрхлэх газар хэмээх 3 газар байгуулж, эдгээр гурван газрын бүх үйл ажиллагааг ДИУ-ын засгийн газраас томилсон Баруун хойд хязгаарын хэргийг бодуулан шийтгэгч бөгөөд гадаад монголын хойчийг сайжруулах элдэв зүйлийг ерөнхийлөн шийтгэгч сайд Сүй Шү Жан байнга удирдаж хянаж байлаа. Үүнээс гадна ДИУ-ын засгийн газар, нийт монголчууд, бурхны шашинд гүн сүсэгтэйг ашиглаж ямар ч эсэргүүцэлгүй номхон хүлцэнгүй байлгахыг хичээсэн бодлого үйл ажиллагаа явуулахыг чухалчилж, монголчууд та нар "монгол газрын цэнгэл ашгийг бодсугай хэмээвээс шарын шашныг дурдан хэлхээ болговоос зохимой, шарын шашныг хэлхээ болгохгүй болваас хэд хэдэн арван түмний олноор ...жаргалан зовлонг сонсохгүй" /УТАФА-4-1-771 1-р нугалбар/ хэмээн ДИУ-ын 9-р оны гуравдугаар сарын 30-нд Сүй Шү Жаны ухуулан зарласан бичигт онцлон тэмдэглэсэн байна. Тухайн үед Монголын хүн ам улам бүр цөөрч буй явдалд монголчууд сэтгэл нэн зовниж байсныг Сүй Шү Жан сайтар ойлгож, энэ талаар монголчуудын анхаарлыг татахуйц зүйл сэдэхийг хичээсэн байдаг. Тиймээс ч тэрвээр монгол нутаг өргөн уудам боловч, хүн ам цөөхөн байна. Хүнгүйгээр ямар ч үйл явдлыг шийтгэж үл чадна. Гэтэл монгол хүний тоо жил хугацаа улирах тутам цөөрсөөр байна. Иймд "хүн амыг олон болгох аргыг хичээвээс ... зуун жил өнгөрсний хойно бидний монгол угсаа мөхөхөд хүрүүзэй" /мөн тэнд/ хэмээн бодож урьд их цэргийн сүрээр "Европ, Ази хэмээх хоёр тивд" алдар гавьяагаа дуурсгаж явсан өвгөдийн үрс тасарвал "нигүүлсэлтэй ч байтугай бас айн эмээлтэй ч байтугай мөн ичгүүртэй болой" /мөн тэнд/ гэж Сүй Шү Жан ухуулсан нь тухайн үеийн монголчуудын сэтгэлд нийцсэн нь эргэлзээгүй билээ. Монголчууд зөвхөн мал адгуулж амь зуулгын гол болгох ба зарим зүйлийг худалдаачдаас авч хэрэгцээгээ хангаж байна. Энэ нь амь зуулга дэвжиж дээшлэхэд тус дөхөм болохгүй учир монголчууд бусдын адил худалдаа эрхэлж сурах явдал нэн чухал гэж Сүй Шү Жан ухуулсан нь зөвхөн монголчуудын амь зуулгыг дээшлүүлэхэд тус дөхөм болох гэсэн санаа бус харин монгол нутагт олноор нь нэвтрүүлэн суурьшуулж байсан хятад худалдаачдыг монголчууд урьдын адил эсэргүүцэхгүй байхыг сургамжлан ятгахад чиглэж байлаа.

Монголын мал сүргийн тоо толгойн өсөлтөд сөргөөр нөлөөлж буй олон шалтгааны нэг нь өвчин эмгэг байсныг Сүй Шү Жан заан тэмдэглээд "малын үржих хорогдох нь даруй бидний монголчуудын аюул буяны ялгал мөн" иймд "хэрхэн хөнгөнөөр үзэж болох аж" /мөн тэнд/ хэмээн онцлон заагаад "мал сайжруулах үржих аргыг үнэхээр ... даруй түргэн эрхэмлэн хянаваас зохих болой" гэж анхааруулжээ. Монголчууд хоол хүнсэндээ мах дагнан хэрэглэдэг уламжлалтай боловч амуу будааг махтай хольж идвэл олон зүйлийн ашигтай, мөн малын арьс ноосоор гэрийн бүрээс зэргийг хийж хэрэглэдэг. Гэтэл үйлдвэр тариаланг огт хөгжүүлээгүйг анхаарч цаашид "тариалан ба үйлдвэрийн хэргийг өчүүхэн ч алгуурлаж үл болох"-ыг зөвлөн сургамжилж ер нь аливаа зүйлийг өөрөө үйлдэхгүй "Бусад хүнийг түшиглэвээс эгнэгт ямар тус буй" хэмээн ухуулжээ. Газар бол аливаа баялгийн эх сурвалж мөн бөгөөд монголын уудам

дэлгэр газар нутаг элдэв зүйлийн “Эрдэнээр баялаг, уурхайн хөрөнгө ба ой мод нь орчлонд тэргүүн байх” /мөн тэнд/ атал хэзээ ч түүнийг ашиглаж байсангүй нь “үнэхээр харамсалтай”. Гэтэл одоо улс орон бүхэн газрын хэвлийн баялгаа олборлож буй төдийгүй бусад улсын газар нутгийн баялгийг ашиглахын тулд дайн байлдааныг үүсгэхэд хүрч байна. Иймд монголчууд энэ баялгаа малтаж ашиглавал “бага эхээр их ашиг олж болох бөгөөд Монголын хөрөнгөөр монголчуудыг тэжээх үүнээс сайн бодлого бий юу” /мөн тэнд/ хэмээн Сюй Шу Жан сануулаад хэрэв газрын баялгаа эс ашиглаваас эцэстээ “Монголын ашгийг хүнд алдах ч байтугай бас ч цэргийн аюулын үүсгэл болох нь болбаас нэхэн гэмшивч завдахгүй” /мөн тэнд/ гэж анхааруулсан байдаг. Энэ бол монголчууд газар дэлхийгээ дээдэлдэг, шүтэж биширдэг уламжлал нь эрдэс баялгаа ашиглахад багагүй саад болж байсныг халж өөрчлөн улсын эдийн засгийг хөгжүүлж хүн ардын аж байдлыг дээшлүүлэхэд ашигт малтмал ой модоо зөв зохистой ашиглах нь томоохон ач холбогдолтойг хүн ардыг ойлгож ухаарахад үнэхээр тус болохуйц санаа байсныг тэмдэглэх ёстой.

Монгол улс, монголчуудын хөгжил дэвшилд эдийн засаг аж ахуй газрын хэвлийн баялгаас гадна ард иргэдийн мэдлэг ухаан, оюуны цар хэмжээ онцгой үүрэгтэйг Сюй Шу Жан цохон тэмдэглэсэн байдаг. Тухайлбал “монгол олон ард төрөлх сэцэн сэргэлэн угтаа онцгой чадал буй”. Гэвч бичиг үсэгт суралцсан хүн цөөхөн бөгөөд ард олны “мэдэл ухаан өдөр өдрөөс буурсан нь” /мөн тэнд/ сэтгэл зовооход хүргэж байна. Ийм учраас тэднийг “сурган хүмүүжүүлэх хэрэг эдүгээгийн маш туйлын чухал зүйл мөн. Жил цаг түлхэж алгуурлаваас үл болмой” /мөн тэнд/ хэмээн монголчуудын мэдлэг боловсролд анхаарал тавих явдал нэн тулгамдсан зорилт болж байгааг дуртган сануулсан нь тухайн үеийн бодит байдалтай нийцэж байлаа.

Дундат иргэн улсаас монголд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бодлогын бас нэг зүйл нь төр засгийн нэр хүнд, үүргийн тухай асуудал байлаа. Тиймээс ч Сюй Шу Жан “өршөөлт засгийг бадруулан явуулна” “хатуу чанга сурган жолоодохыг үл дагуузай хэмээхүл цэрэг эрүү тогтоон сүрдүүлмүй” /мөн тэнд/ хэмээн төр засаг энэрэн өршөөх залхаан цээрлүүлэхийн аль алийг хослон ард иргэнийг удирдан жолоодох болно. Тэгэхдээ “иргэдийг ятгаж сайнд оруулж муугаас ангижруулах” явдалд засаг төрийн гол бодлого чиглэж байна гэдгийг сануулсан байна.

Дундат иргэн улсаас Монголд хэрэгжүүлэх энэхүү бодлогын гол агуулгыг сайд Сюй Шу Жан хэд хэдэн удаа тусгай бичгээр монголчуудад ухуулан зарласан байна. Тухайлбал Дундат иргэн улсын есдүгээр оны II сарын 3, III сарын 20-нд 2 удаа зарласан бичгийг бид олж үзсэн юм. /Н.Магсаржав “Монгол Улсын шинэ түүх” УБ 1994 167 дахь талд: УТА ФА-4-1-171 нэгдүгээр нугалбар/. Гэвч эдгээр бичиг агуулгын хувьд ижил боловч үг үсгийн бага зөрүүтэй бөгөөд агуулга нь 1920 оны VI сарын 16-нд Нийслэл Хүрээнд Сюй Шу Жаны зарлан хуралдуулсан монгол олон ван гүнгийн хуралд түүний хэлсэн үгэнд ч бас тусгалаа олсон байдаг. Харин энэхүү хурал дээр тэрбээр үг хэлэхдээ хэд хэдэн асуудлыг нэлээд тодруулж зарим зүйлийг цоо шинээр илтгэж монгол ноёдын санал бодлыг асууж ярилцсан байна. Тухайлбал, Энх-Амгалан, /1662-1722/ Төр гэрэлт /1821-1850/ хаадын үед “Эрхүү Чита-гийн зэрэг газруудыг Орост булаагдан алдсан” /УТА А/4-1-783/ учир болвоос тэр үед Манж улсын хил хязгаарыг нарийвчлан тодорхойлсон газрын зураггүй байсантай холбоотой байлаа. Иймээс одоо Монголын бүх хошууд тус бүрийнхээ нутгийн зургийг үйлдэж дансны хамтаар мэдүүл гэж хуралд оролцогчдоо сануулсан байдаг.

Мөн цаашид Улсын хэмжээний бүх ноёдын хурлыг тусгай хугацаа тогтоон хуралдуулж байвал ажил хэрэгт тус дөхөмтэй. Бас аймаг бүрийн чуулган тус тусдаа хуралдаж хэрэг явдлаа хэлэлцэж байгтун гэжээ.

Монголчууд морийг эрхэмлэдэг учир хурдан морь уралдах хурлыг жил бүрийн зуны дунд сард Нийслэл Хүрээ, Улиастай, Сайр ус гурвын аль нэгэнд зохион байгуулж болох ба хурдан сайн морины эзэнд тусгай цол шагнаж байх нь ажил явдалд тустай гэж тэрбээр ярьсан байна.

Энэхүү хуралд оролцсон бүх ноёд саналаа нэгтгэж, 1918 онд Чин И-гийн төлөвлөсөн 64-н зүйлийг сэргээн хэрэглэх нь зүйтэй хэмээн тусгай бичиг үйлдэж Сүй Шу Жанд өргөсөн байна. Гэвч тэрбээр "Энэ жаран хэдэн зүйл хэргийг би хэлэлцэж чадахгүй. Энэ болбаас хэдхэн хүний биеийн ашиг тусыг бодсоноос бус газар орон ба олон ардад тустай зүйл үгүй тул би хэлэлцэхгүй ... Хэрэв зөрчөөс ял хэлэлцмүй ... Энэ удаа бүх монголын ашиг бодмуй. Нэг хоёр хүний завшааныг үл бодмуй" ЛУТА ФА-4-1-783/ хэмээн хариу мэдэгдсэн байна.

Ард олноос хураах алба татварыг "хөнгөн болгож баян элбэгт давших ба ... ардын хөрөнгийг хүндэтгэж олон албат нарын зовлонг нигүүлсэн бодох хэрэгтэй. Энэ бол ардын албыг хөнгөтгөх нэгэн зүйл буюу" /мөн тэнд/ хэмээн Сүй Шу Жан энэ хурал дээр анхааруулсан нь ард олны сэтгэлд нийцсэн үг байлаа.

Ард олныг эрдэмд боловсруулахын тулд "сургууль байгуулна. Энд /Нийслэл хүрээнд З.Л./ дунд сургууль байсан нь төдий л боловсорсонгүй бөгөөд цөөхөн байжээ" гэж тэмдэглээд "одоо тус тусын хошуунаас хөвгүүдийг томилон ирүүлж сургуульд оруулж боловсруулан хэрэг шийтгүүлэх нь тустай" гэж мэдэгдсэн байна.

Монголчууд ой модыг түлшинд ихээр хэрэглэж байгааг шүүмжлээд өтгөн ойгоос ургаж гүйцсэн модыг авч ашиглаж бай. Нялх залуу модыг бүү огтолж сүйтгэ гэж анхааруулсан байна. Мөн хурал дээр тэрбээр Монголын ирээдүйн хөгжилд төмөр зам, банк, цахилгаан станц чухал үүрэгтэйг хэд хэдэн зүйлээр нотлон ярьж Монгол нутагт төмөр зам тавих, банк байгуулахад Монгол ноёд зохих хувь хөрөнгө оруулбал жирийн ард иргэд бас дуурайж хувь нэмэр оруулах болно. Гэвч энэ хэрэгт зарцуулах хөрөнгийн их төлөвийг улсын сангаас гаргана гэдгийг онцлон тэмдэглэжээ. Монголчууд 2000 гаруй жил бурханы шашин шүтсээр ирсэнийг Сүй Шу Жан тэмдэглээд шашнаа дээдлэн "өдөр бүр санаа агуулж хөгжүүлэхийг санаж байх хэрэгтэй" /мөн тэнд/ гэж сануулжээ.

Мөн монголчууд өвчин тусваас ном гүрэн, эмээр хослон эдгээхийг гол болгодог. "Би ард олны амь биеийг хамгаалахыг эрхэмлэн үзэж эмчийн хүрээлэн нэсэн ... тул үүнээс хойш аливаа өвчтөн хүн эмчийн хүрээлэнд ирж засуулбаас зохимой. Ер өвчнийг засаж эдгээхэд сүйтгэл төлбөр огт гаргуулахгүй" гэдгээ зарлаж мэдэгдсэн байна.

Ингэж Дундат иргэн улс өөртөө нэгтгэж захирсан монголын талаар явуулах бодлого төлөвлөж хэрэгжүүлж эхэлсэн байна. Эдгээр бодлого бүгд ажил хэрэг болж амжаагүй боловч монголчуудын сэтгэлд нийцэхүйц зүйл цөөнгүй байлаа. Тодруулж хэлбэл, Дундат иргэн улсын гол бодлого нь монголын ард түмний эрх ашгийг дээдлэн хүндэтгэхийг чухалчлахаасаа илүү хятадын эрх ашгийн үүднээс монголын мал аж ахуй эдийн засаг, газар нутгийн баялгийг хэрхэн ашиглах вэ? гэдгийг урьдал болгож байсан төдийгүй 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалтын үр дүнд монголчууд Манж дайчин улсын эрхшээлээс ангигирч, төрийн тусгаар тогтнолоо сэргээснийг Дундат иргэн улс зүй бус үйлдэл байсан мэтээр үзэж тэрхүү хувьсгалын үед монголд үйл ажиллагаа явуулж байсан хятадын пүүсүүд багагүй хохирол амссан хэмээн түүнийг төлүүлэхийг тулган шаардаж байлаа. Бидэнд олдлоод буй мэдээгээр бол зөвхөн Ховдын хязгаараас тэмээ 55000, адуу 75000, үхэр 400000, хонь хагас сая гаруйг нөхөн төлүүлэхээр Сүй Шу Жан нэхэмжилж байлаа. Гэтэл тэр үед Ховдын хязгаарын бүх тэмээ 35000, адуу 130000, үхэр 120000, хонь 2 сая орчим байсан нь тэрхүү өрийг төлөх ямар ч бололцоогүй нь тодорхой билээ. Иймээс ч

Монголчууд Дундат иргэн улсын төр засаг монголын талаар цаашид ямар бодлого явуулах вэ гэдгийг сайтар мэдэж байлаа. Ер нь Дундат иргэн улс монголын талаар баримтлах бодлогодоо олон зүйлийг амласан боловч ард олны итгэлийг татахуйц бодитой ажил хэрэг өрнүүлж, хүн ардад тус болж байсан талархал дэмжлэгийг нь хүлээсэн ямар нэгэн шинэ сэргэг зүйлийг тухайн үед огт хэрэгжүүлээгүй нь монголчуудын олонхи Дундат иргэн улсаас аль болохоор салан тусгаарлахыг хичээхэд хүргэсэн юм.

SUMMARY

Researching the Chinese Policy on Mongolia (since 1919)

In November 1919, after the Chinese military force destroyed Mongolian Autonomy, Chinese Government determined its policy on Mongolia. The content of Chinese policy was to win confidence of Mongolian people. By their policy they prepared to renovate Mongolian traditional religion, animal husbandry, economy, tax and trade.

They declared that they would pay attention to Mongolian people's health by building hospitals and treating patients free of charge. However, Chinese Government didn't take any measures to implement these things, therefore Mongolian people struggled China for their independence.